

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.12.08

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын зах зээл сул үзүүлэлтүүдийн дунд хүү бууруулах хүлээлт өсөлтөө хадгалж, жижиг хувьцаанууд илүү хүчтэй сэргэлт үзүүлж байна.
- Retail sales, PPI, consumer confidence зэрэг тоонууд эдийн засаг зөөлөн хөрж буйг харуулсан ч энэ нь ХНСС-ийн бодлого зөөлрөх орон зайг нэмэгдүүлжээ.
- S&P 500 дээр H&S унах эрсдэлийн зураг бүрэн хүчингүй болох түвшин 6,950, харин 6,550 доош эвдвэл доошоо чиглэл давамгайлах магадлал өндөр байна.
- Хятадын зах зээлд үйлдвэрлэлийн ашгийн уналт (PPI) 37 сар дараалан сөрөг байгаа нь Хятадын эдийн засаг IV улиралд momentum алдаж буйг харуулж байна.
- Гэсэн ч БНХАУ-д бодлогоор дэмжигдсэн нөхцөл байдал, AI эрэлт, хөрөнгө оруулагчдын sentiment сайжирсан нь Hang Seng-ийг 28–30 мянгад чиглэсэн өсөлтийн циклд байгааг нотолж байна.

S&P 500 индексийн
2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна

ОНЦЛОХ ХУВЬЦАА: NVDA КОМПАНИЙН ХУВЬЦААГ \$160 ХАНШИД АВАХ ТОХИРОМЖТОЙ



АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.12.01-12.07

АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 12-Р САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГТ ӨСӨЛТТЭЙ ХААГДЛАА

АНУ-ын голлох хөрөнгийн индексүүд 12-р сарын эхний долоо хоногийг өсөлттэй хааж, өмнөх долоо хоногийн ашиг өсөлтөө үргэлжлүүлээ. Холбооны нөөцийн сан (Fed) ойрын хурлаараа хүүгийн түвшинг бууруулах магадлал нэмэгдсэн нь хөрөнгө оруулагчдын хүлээлтийг дэмжсэн байна. Nasdaq Composite индекс 0.91%-иар өсөж хамгийн өндөр гүйцэтгэл үзүүлэв. Russell 2000 индекс 0.84%-иар нэмэгдлээ. S&P 500 индекс арай удаан өссөн ч долоо хоногийг эерэгээр хаалаа. T. Rowe Price компанийн арилжаачдын мэдээлснээр, долоо хоногийн ихэнх хугацаанд арилжааны идэвх харьцангуй сул байжээ.

ҮЙЛДВЭРЛЭЛ АГШИЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР ХАМГИЙН ХУРДАЙ ТЭЛЖ БАЙНА

АНУ-ын үйлдвэрлэлийн салбар 11-р сард дараалан 9 дэх сардаа агшсан тухай Хангамжийн менежментийн хүрээлэн (ISM) мэдээлэв. Тус байгууллагын мэдээлснээр: Үйлдвэрлэлийн PMI индекс 48.2 болж, 10-р сарын 48.7-оос буурсан байна. (50-оос доош үзүүлэлт нь агшилт, 50-иас дээш бол тэлэлт гэдгийг илэрхийлдэг.) Нийлүүлэлт, шинэ захиалга, ажлын байрны тоо буурсан нь энэ уналтад голлон нөлөөлжээ. Эсрэгээр, үйлчилгээний салбарын PMI 52.6 болж, 10-р сараас 0.2 нэгжээр өссөн бөгөөд энэ нь сүүлийн 9 сарын хамгийн өндөр түвшин юм.

ХУВИЙН ХЭВШЛИЙН АЖЛЫН БАЙР ОГЦОМ БУУРЛАА

Лхагва гарагт цалин хөлсний дата боловсруулагч ADP компани 11-р сард хувийн хэвшлийн ажлын байр 32,000-аар буурсан тухай мэдээллээ. Энэ нь 10-р сарын 47,000-ийн өсөлтөөс эрс эсрэг чиглэлд эргэсэн үзүүлэлт бөгөөд 2023 оны 3-р сараас хойших хамгийн том уналт боллоо. ADP-ийн ахлах эдийн засагч Нела Ричардсон:

“Хэрэглэгчдийн болгоомжлол, макро эдийн засгийн тодорхой бус байдал нь ажилд авах явцыг тогтворгүй болгож байна. 11-р сарын уналт нийт салбарыг хамарсан ч жижиг бизнесүүдийн бууралт голлон нөлөөллөө” хэмээн тайлбарлав.

Мөн Challenger, Gray & Christmas компанийн мэдээлснээр, 11-р сард АНУ-д 71,000 гаруй ажлын байр цомхотгох шийдвэр зарлагдсан нь 2022 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Ингэснээр 2025 оны эхнээс хойших нийт ажлын байрны цомхотгол 1.17 саяд хүрч, 2020 оноос хойших дээд түвшинд хүрээд байна. Харин хөдөлмөрийн яамны мэдээллээр, 11-р сарын 29-нд дууссан долоо хоногт ажилгүйдлийн тэтгэмжийн анхны хүсэлт 191,000 болж, өмнөх долоо хоногоос 27,000-аар буурсан нь 2022 оны 9-р сараас хойших хамгийн доод түвшин боллоо.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.12.01– 12.07

ХЯТАДЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ТЕХНОЛОГИ, AI-ИЙН НӨЛӨӨГӨӨР ӨСЛӨӨ.

Эх газрын Хятадын хөрөнгийн зах зээл дотоодын технологи, хиймэл оюун ухааны салбарын арилжааны идэвх нэмэгдсэнээр эдийн засгийн удаашралын талаарх сөрөг мэдээллийг түр халхалж, өсөлттэй хаагдлаа. CSI 300 индекс 1.28 гаруй хувиар өсөв. Shanghai Composite индекс 0.37 гаруй хувиар нэмэгдлээ. Харин Хонконгийн Hang Seng индекс 0.87 гаруй хувиар өссөн байна.

Үйлдвэрлэл ба үйлчилгээний PMI эдийн засгийн сулралыг илтгэв. Хятадын албан ёсны үйлдвэрлэлийн PMI индекс 11-р сард 49.2 болж, 10-р сарын 49.0-ээс ялимгүй сайжирсан ч дараалан 8 дахь сардаа 50-оос доош түвшинд хадгалагдлаа. Энэ нь эдийн засгийн өсөлт бус, агшилт үргэлжилж буйг илтгэж байгаа бөгөөд Bloomberg-ийн мэдээлснээр ийм урт хугацааны бууралт түүхэндээ хамгийн удаан үргэлжилсэн үзүүлэлтүүдийн нэг болж байна. Мөн үйлдвэрлэлээс бусад салбарын (барилга, үйлчилгээ) PMI 10-р сарын 50.1-ээс 11-р сард 49.5 болж буурсан нь сүүлийн бараг 3 жилийн хугацаанд анх удаа агшилт үүссэнийг харуулж байна. Үүний гол шалтгаан нь үл хөдлөх хөрөнгө, орон сууцны үйлчилгээний салбарын сулрал байжээ.

Үл хөдлөхийн хямрал эдийн засгийн хамгийн том эрсдэл хэвээр байна. Сүүлийн PMI үзүүлэлтүүд нь Хятадын эдийн засаг 4-р улиралд эрчээ алдаж байгаагийн тод илрэл болж байна. 2020 онд Бээжингээс хэрэгжүүлсэн “Гурван улаан шугам” бодлогоор барилга, үл хөдлөх хөрөнгийн компаниудын зээлийн өсөлтийг хязгаарласнаас хойш үл хөдлөхийн зах зээлд гүн хямрал эхэлсэн. Энэхүү хямрал нь:

- Хэрэглээний идэвхийг сулруулж,
- Үнийн бууралтад (дефляц) дарамт үүсгэж,
- Эдийн засагт хамгийн том системийн эрсдэл болоод байна.

Гэсэн хэдий ч ихэнх шинжээчид Хятад улс 2025 оны эдийн засгийн өсөлтийн ойролцоогоор 5%-ийн зорилтоо нэмэлт бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүйгээр биелүүлж чадна гэж үзэж байна.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases									
		for the week beginning									
		December 01, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
HAFN	CREDO	BNS	MARVELL	DLTR	SALESFORCE	GG	DOCU	MMY			
HAFNIA	CREDO	Scotiabank	MARVELL	DOLLAR TREE	salesforce	DOLLAR GENERAL	DocuSign	MoneyHero			
	MOBI	SIG	GTLB	M	SNOW	KR	RBRK	VSCO			
	mongoDB	SIGNET JEWELERS	GitLab	macys	snowflake	Kroger	rubrik	VICTORIA'S SECRET			
	SLP	UNFI	CRWD	RBC	AT	TGRI	S	KNOP			
	SimulationsPlus	BETTER FOOD. BETTER FUTURE.	CROWDSTRIKE	CMX	C3.ai	UP Fintech 老虎證券	SentinelOne	KNOT Offshore Partners LP			
	CANG		PURESTORAGE	sprinklr	PATH	HRL	ULTA BEAUTY				
	CANGO 瑞合		AEO	THOR	UiPath	Hormel Foods	CHPT				
	VST		AMERICAN EAGLE OUTFITTERS	THO	FIVE	WORKSHOP	chargepoint				
	vestis		OKTA	THOR	GWRE	CIBC	samsara				
			BOX	THOR	GWRE	SAIC	HPE				
			ASANA	THOR	HOY	SAIC	Hewlett Packard Enterprise				
			LESLIE'S	THOR	DSGX	TD Bank	COO				
				THOR	DESCARTES	Donaldson	Cooper Companies				
				THOR	PVH	HOV	Argan, Inc.				
				THOR	TLYS	Hovnanian Enterprises Inc	SPORTSMAN'S WAREHOUSE				
				THOR	TILLYS						

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases									
		for the week beginning									
		December 08, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
TOL	CPB	GME	CHWY	ORCL	CEN	AVGO	JOUT				
Toll Brothers	Campbell's	GameStop	chewy	ORACLE	ciena	BROADCOM	JOHNSON OUTDOORS				
PHR	SAIL	AVAV	PLAB	ADBE	MANU	LULU					
Phreesia	SailPoint	AeroVironment	PHOTRONICS UEC	Adobe	HOOKER	lululemon					
OOMA	ASO	Trucker Control	UEC Uranium Energy Corp	SNPS	HOFT	COST					
Ooma	Academy	CASEY	REV	SYNOPSIS	HI	COSTCO WHOLESALE					
CMP	AZO	Casey's	VEHICLES FOR LIFE	planet.	VRA	RH					
Compass Minerals	AutoZone	braze	JILL	AMTECH	Vera Bradley	NTSK					
MAMA	CGNT	ARQIT	MOMO	ELVA	LOVESAC	netskope					
Mama's Creations	COGNITEC	Lakeland Industries Inc	學文集團	electrovaya	QUANEX	Quanex building products					
	ARQ	OLLIE'S GOOD STUFF CEREAL	DAKT	OXFORD	MITEK	Mitek					
	ARQ	FERGUSON	DAKTRONICS VBNK	OXFORD	KMTS	kestra					
	ARQ	KFY	VersaBank	NORDSON	KMTR	kestra					
	ARQ	KORN FERRY	AMERICAN OUTDOOR BRANDS	SKIL	DLHC	DLH					
	ARQ	GII		DLHC							

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers